



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар A/190

Арвайхээр сум

**Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.4.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, хавсралтаар баталсугай.

2.Насан туршийн боловсролын төвийн дэргэдэх “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхим”-ыг түшиглэн орон нутагт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг тасралтгүй, чанартай зохион байгуулахыг салбар зөвлөлийн дарга (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/05 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0378

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 13-ны өдрийн 1190 дугаар
захирамжийн хавсралт



САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Боловсролын ерөнхий газрын харьяа аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Боловсрол, шинжлэх ухааны газрын харьяа аймгийн Политехник коллежийн захирал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын салбарын бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Залуучуудын хөгжлийн төвийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Боловсрол, шинжлэх ухааны газрын дизайн, технологийн сургалт хариуцсан ахлах арга зүйч

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Боловсрол, шинжлэх ухааны газрын харьяа аймгийн Политехник коллежийн Нийгмийн түншлэл үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Боловсролын ерөнхий газрын харьяа аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн сургалтын менежер